



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/446

Мандалговь

“Нутгийн чулуу” ардын дуу дуулаачдын
уралдаанд дэмжлэг үзүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.10, 16.1.12, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2.1.4, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3.4 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дуу хуурын өлгий нутгийн алдартан, гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулах зорилгоор Өлзийт сумын уугуул Монгол Улсын Ардын жүжигчин Адилбишийн Дашпэлжээгийн нэрэмжит “Нутгийн чулуу” ардын дуу дуулаачдын уралдааныг 2021 оны 12 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

2. Дээрх уралдааны тэргүүн байрын шагналд шаардагдах 500,000 (Таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

